



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/524

Ховд


Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дарви сумын Соёлын төв үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг тохиолдуулан ардын болон сонгодог урлагийг орон нутгийн иргэдэд хүргэх, олон угсаатны өв, соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн авъяас чадвараа дайчлан ажиллаж буй Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, ардын авъяастан Д.Жаргалыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Д.Жаргалд 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Д.Түмэн-Өлзий/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ